



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/67

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Үенч сумын төвийн тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|                       |            |  |
|-----------------------|------------|--|
| Дарга:                | Ш.Нохойжав | - Орон нутгийн өмчийн газрын дарга             |
| Гишүүдэд:             | Д.Болормаа | - 16 дугаар цэцэрлэгийн эрхлэгч                |
|                       | М.Адуучин  | - Төрийн бус байгууллагын төлөөлөл             |
|                       | Н.Чинбат   | - Иргэний төлөөлөл                             |
| Нарийн бичгийн дарга: | Д.Дариймаа | - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн |

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Д.Дариймаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД